

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 16

Дархан-Уул аймаг

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах байгууллага	Хугацаа	Хэрэгжилтийн талаарх тэмдэглэл
1	2	3	4	5
1.	БОАЖЯамны хэн гэдэг, ямар албан тушаалтай хүн баавгайг устгах тухай үүрэг чиглэлийг өгсөн тухай хариуцах эзэнтэй болгож албажуулаарай.	Хонгор сум	2019.09.27	2 удаагийн малчдаас ирсэн дуулагын дагуу Баавгай нь байхгүй байсан учраас /тааралдаагүй/ устгаагүй байна.
2.	Б.Оргилсайханыг ажлаас чөлөөлөх тухай яамнаас үүрэг чиглэл ирүүлсэн гэж байна. Ажлыг энэ 7 хоногт хүлээлцэх	Төрийн захиргааны удирлагын хэлтэс	2019.09.27	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын офицер ахмад Б.Оргилсайханыг АЗДТГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 2-Б/63 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж, ажлыг хүлээлцлээ.
3.	Шуурхай хурлын цагийг ирэх 7 хоногийн 1 дэх өдрөөс эхлэн /2019.09.23/ 08:00 цагт болгоё. Удирдлагууд хүлээн зөвшөөрч байна. уу. Санал байхгүй учраас дараагийн шуурхай хурлаас эхлээд цагаа өөрчилъе	Бүх байгууллагын удирдлагууд	2019.09.23	2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Шуурхай хурлыг 08:00 цагаас эхлэн явуулж байна.
4.	Брак байруудын айл өрхүүд түрээсийн төлбөрөө төлж байна уу. ОНӨГ-аас олон нийтийн саналыг авч хэлцүүлэгийг зохион байгуулсаны дараа аймгийн ИТХ-хуралд танилцуулах ёстой гэтэл танай байгууллага ажлаа хийхгүй байна. 7 сард айл өрхүүд байрандаа орсон одоо 9 сар дууслаа. Яаралтай энэ ажлыг зохион байгуулж дуусгах ИТХ-ын хуралд оруулах	Орон нутгийн өмчийн газар	2019.09.27	Дахин төлөвлөлтийн хүрээнд баригдсан 60 айлын орон сууцны 12 орон сууц нь Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй бөгөөд сонгон шалгаруулалтаар 8 айл орсон. 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр "Орон сууц түрээслүүлэх түр гэрээ"-г байгуулсан бөгөөд одоогоор 689.400 төгрөгийн түрээсийн төлбөр тус газрын дансанд орсон байна. Түрээсээ төлөөгүй айлуудын төлбөрийг нэн даруй төлөхийг мэдэгдсэн. -Орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууц болон грашын төлбөрийн жишиг үнийг тогтоох тухай тогтоолыг төслийн 2019,09,18-ны өдөр Иргэний танхимтай хамтран иргэдээс санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус тогтоолын төслийг ИТХурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.
5.	Архивын улсын үзлэгт манай аймаг дэндүү хангалтгүй орлоо. ХШҮДАХ-ийн дарга үүнд анхаарах 6 байгууллагад түүвэрчилсэн шалгалт	Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс	2019.09.27	Улсын үзлэгийн ажлын хэсгээс аймгийн нэгдсэн шалгалтын урьдчилсан дүн мэдээг 09 дүгээр сарын 25-ны өдөр Архивын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн тухай

	хийхэд үнэхээр хангалтгүй байсан учраас хяналт шалтгалт хийх			мэдээ ирүүлсэн. Архивын улсын үзлэг явуулсан тухай урьдчилсан илтгэх хуудсын дүн мэдээ, Илтгэх хуудсыг ирүүлээгүй учраас гарсан зөрчил дутагдалгүй арилгах салбар комиссын ажил хүлээгдэж байна.
6.	БСУГазрыг сонгож улсын үзлэгийн шалтгалт орно гэж хэлсэн 3 хоногийн дараа шалгахад анх ямар байсан яг тэр чигээрээ огт бэлтгэж ажиллаагүй байсан. Энэ байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч хариуцлага тооцох	Нийгмийн бодлогын хэлтэс, Архивын улсын үзлэгийн салбар комисс	2019.09.27	Улсын үзлэгийн ажлын хэсгээс аймгийн нэгдсэн шалгалтын урьдчилсан дүн мэдээг 09 дүгээр сарын 25-ны өдөр Архивын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн тухай мэдээ ирүүлсэн. Архивын улсын үзлэг явуулсан тухай урьдчилсан илтгэх хуудсын дүн мэдээ, Илтгэх хуудсыг ирүүлээгүй учраас гарсан зөрчил дутагдалгүй арилгах салбар комиссын ажил хүлээгдэж байна.
7.	Аж ахуй нэгж байгууллага, агентлагууддаа ахиж шалгаж, хяналт тавьж ажиллах	Архивын улсын үзлэгийн салбар комисс	2019.09.27	Дархан сумын ЗДТГ- нийт албан хаагчид болон багуудын Засаг дарга нийгмийн ажилтнуудад зориулсан албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалт, гарсан зөрчил дутагдалыг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.
8.	Тендерийн сонгон шалгаруулалтын нэгдсэн дүн тайланг танилцуулах, тайлан баланс, бүртгэл, өмч хадгалалт, хамгаалалт, талаарх ажил таг байна. Энэ талаар мэдээ, мэдээлэлдээ тусгах	Орон нутгийн өмчийн газар	2019.09.27	Тус газар нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд орон нутгийн бмчийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн ажлуудыг тухай бүр гүйцэтгэн ажиллаж байна
9.	Сургууль, цэцэрлэгт нэг бүрчлэн очиж уулзаад сургууль цэцэрлэгийн өвөлжилтын бэлтгэл ажил, дулаан шугам сүлжээний асуудалд анхаарах, БСУГ-ын дарга энэ ажилд огт анхаарахгүй байна. Сургууль, цэцэрлэгийн шугам сүлжээ, өвөлжилтийн бэлтгэл ажил ЗАА болон Засаг даргын ажил юм шиг боллоо. Үүнд анхаарах	Нийгмийн бодлогын хэлтэс	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
10.	Их дээд сургуулиудын оюутнуудыг ногоо хураалтанд хамруулах, Их дээд сургуулийн удирдлагуудтай уулзах А.Түвшинбат даргын өрөөнд уулзалт зохион байгуулж хуваарь гаргах	Нийгмийн бодлогын хэлтэс	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
11.	Т.Ганболд дарга сумдаар явж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж байгаа. Шарын гол сумын 6 дугаар цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн үйл	Нийгмийн бодлогын хэлтэс	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй

	ажиллагаа эхлээгүй байхад БСУГ-ын газрын дарга мэдээгүй байна. Үүнд анхаарах			
12.	ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг хэлтэс, хэлтсээр нь гаргаж үнэлэлт, дүгнэлт өгж, удирдлагуудын түвшинд дүйцүүлэх байдлаар дүгнэж ярилцъя.	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс	2019.09.27	2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүх хэлтэс, агентлагуудаас тайланг авч нэгтгэн урьдчилсан үнэлгээг Засаг даргын Тамгын газрын дарга болон холбогдох хэлтсийн дарга нарт танилцууллаа.
13.	Эдийн засаг нийгмийн үүндсэн чиглэлд залуучуудын чуулганаас санал авах, төлөвлөгөөний урьдчилсан төсөл гаргах	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	2019.09.27	Эдийн засаг нийгмийн үндсэн чиглэлд тусгах санал авах хүснэгтийг Абле програмын олон нийтэд нээлттэй байршуулан хэлтэсүүдээс төсөлд тусгах саналыг авч ТЗУХ-т нэгтгэж байна.
14.	БНСУ-руу явуулах албан бичигт нэмэлт засвар хийж танилцуулах Үүнд: 2020 онд эмч нарыг сургалтад хамруулах, ОБГ-ын алба хаагчдыг сургалтад хамруулах, БНСУ-ын дэмжлэгтэй ухаалаг анги бий болгох талаар тусгах	Төрийн захиргааны удирлагын хэлтэс	2019.09.27	Албан бичигт нэмэлт өөрчлөлтийг оруулж цахимаар болон цаасаар хүргүүлсэн
15.	Газрын төлбөр барагдуулах ажил ямар түвшинд явагдаж байна. Төлбөр барагдуулалтад анхаарах	Санхүү төрийн сангийн хэлтэс	2019.09.27	08 дугаар сарын мэдээгээр 147.8 сая төгрөгөөр тасарч байсан бол 09 дүгээр сарын 23-ны байдлаар 119.8 сая төгрөгөөр тасарч 28.0 сая төгрөг тухайн хугацаанд нэмэгдэж орсон байна. Газрын төлбөрийн асуудлаар 10 дугаар сард ГХБХБГазрын албан хаагчидтай аймгийн Засаг дарга, СТСХ, Татварын хэлтэстэй хамтарсан уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
16.	1500 оюутны чуулга уулзалтад ЗД-ийн илтгэл тавих 2 зааланд зэрэг илтгэл тавигдана. Илтгэлийг маш өндөр хэмжээнд бэлдэх	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс	2019.09.27	Аймгийн Засаг даргын илтгэлийг бэлтгэж Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан нэмэлт саналыг авч илтгэлд тусган Засаг даргад илтгэлийг бэлэн болгож өглөө.ы
17.	Оюутны чуулга уулзалтыг Форум хэлбэрээр зохион байгуулах тул мэдээ, мэдээллийг сайтар хийх	Мэдээлэл технологийн алба	2019.09.27	Оюутны чуулга уулзалтыг мэдээ мэдээллийг тухай бүр авч МАН-ын page хуудсаар нийтэд мээллэх мэдээг хүргүүллээ.
18.	ИТХ-ын төлөөлөгчид агентлагийн удирдлагууд үл тоох байдал гаргаж асуудал шийдвэрлэхгүй байгаа талаар гомдол мэдээллэж байна. Удирдлагууд төлөөлөгчдыг үл тоох байдал анхаарах, Жишээ нь: Хичээлийн шинэ жилийн нээлтэд тухай тойргийн төлөөлөгчийг уриагүй тухай гомдол бас ирж байна. гэх мэт асуудалд анхаарах, ИТХ-	Бүх байгууллагын удирдлагууд	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй

	ын хуралдаанд танилцуулагдаж байгаа асуудалуудад байгууллагууд анхаарах			
19.	Дижитал шилжилтын хүрээнд тараах I rad одоо болтол ирээгүй байна. хэдэн долоо хоног болж байна.	Мэдээлэл технологийн алба	2019.09.27	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон аймгийн удирдлагуудад нийт 14 ширхэг I rad-ийг албаны хаяг үүсгэн бүртгэлжүүлж хүлээлгэн өглөө.
20.	Хадлан тариалан, ногоо хураалтыг хийх оюунуудыг хүлээж авах	Сумдууд	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
21.	АТГ-аас ирүүлж байгаа албан бичгийн дагуу тухай байгууллага дээр очиж хяналт шалгалт хийх	Хууль, эрх зүйн хэлтэс	2019.09.27	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
22.	Хэдэн албан хаагчид өрөөндөө суугаад гадуур явж ажил хийхгүй байна. Өрөөндөө чихэвч зүгээд Засаг дарга орж ирж байхад үл тоож байна.	Захирагчийн алба	2019.09.27	2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Захирагчийн ажлын албаны хурал дээр хэлтсийн мэргэжилтнүүдэд сануулга өгч, өөрийн хариуцсан ажилдаа анхаарч ажиллах талаар үүрэг чиглэл өглөө.
23.	Иргэдийг нааш, цааш явуулахгүй байх, чирэгдүүлэхгүй байхад анхаарах мэдээллийг үнэн зөв тодорхой өгөх, яалангуяа хөдөө орон нутгийн иргэдийг чирэгдүүлэхгүй байхад анхаарах	Бүх байгууллагын удирдлагууд	2019.09.27	ТЗУХ-ээс сумдын Засаг даргын Тамгын газарт сумдын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд чирэгдэл учруулахгүй байх талаар үүрэг чиглэл өгч төрийн үйлчилгээг авахад дэмжлэг үзүүлж ажиллах талаар зөвлөлөө.

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ